


“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 9 2022 оны 7-р сар

ТӨСЛИЙН ХОЁРДУГААР ШАТНЫ ҮР ДҮН

“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн хоёрдугаар үе шат дараах үр дүнд хүрэхийг зорьж байна. Үүнд:

1. Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах
   - а.Төслөөс шинэлэг, олон улсын сайн туршлагыг тусгаж, бодит байдалд нийцүүлэн, өртөг зардлын хувьд хэрэгжихүйц, хаалтын дараах нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг дэмжсэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуйц уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах;
   - б.Уурхайн хаалтын хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах боломжийг эрэлхийлж, зөвлөмж гаргах.

2. Уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах баг, оролцогч талууд болон нутгийн иргэдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх
   - а.Төлөвлөлтийн багийн гишүүдийг уурхайн хаалтын талаарх мэдлэг, ойлголтоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, суралцах боломжоор хангах;
   - б.Нутгийн ард иргэдэд уурхайн хаалтын төлөвлөгөөний талаар мэдээлэл хүргэж, олон нийтийн уулзалт хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх.

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Салхитын уурхайд хийсэн хээрийн судалгааны ажил

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Эм И Си Эс Зэт Би” компани 2022 оны 6 сарын 29-өөс 7 сарын 2-ны өдрүүдэд Салхитын уурхайн талбайд ажиллаж, байгаль орчны шинжилгээний холбогдох сорьц авав. “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК судалгааны багт аюулгүй ажиллагааны талаар сургалт явуулж, холбогдох цэгүүдээс сорьц авахад хамтран ажиллалаа.

Төслийн 1-р шатанд хийж гүйцэтгэсэн байгаль орчны төлөв байдлын суурь судалгаанд байгаль орчны дутуу өгөгдөл, мэдээллийг нөхөж цуглуулахыг зөвлөсний дагуу сорьц авах ажлыг зохион байгуулав.

Уг судалгаагаар уурхайн чулуулгийн болон хөрсний овоолгын химийн найрлага, шимт хөрсний овоолгын чанар, химийн найрлага, төлөв байдал, уурхайн карьер доторх усны химийн найрлагыг тодорхойлох зорилготой юм.

Энэхүү мэдээлэл нь нөхөн сэргээлтийн чиглэлээрх төлөвлөгчид уурхайн хаалтын жишиг стратегийг Монгол улсын хууль тогтоомжид заасан байгаль орчны стандартад нийцүүлж, нөхөн сэргээсэн газрыг нийтийн хэрэгцээнд аюулгүй байхаар боловсруулахад чухал хэрэгцээтэй юм.



Зураг 1. “Эм И Си Эс Зэт Би” компанийн судлаачид “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн төлөөллийн хамт Салхитын уурхайд



Зураг 2. “Эм И Си Эс Зэт Би” компанийн судлаачид Салхитын ордын хаягдал чулуулгаас сорьц авч буй нь

Судалгааны баг “Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн хяналт-шинжилгээний хээрийн гарын авлага” (2022)-ыг удирдамж болгон ашиглаж, MERIT төслөөс сорьц авах нарийвчилсан арга зүйгээр хангасан. Хүснэгтээс цуглуулах шаардлагатай сорьц болон холбогдох лабораторийн шинжилгээг харна уу. Шинжилгээний үр дүнг баталгаажуулах үүднээс сорьцын төрөл тус бүрээс чанарын хяналтын сорьц авсан болно. Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх и-мэйл хаягаар MERIT төсөлтэй холбогдон авах боломжтой.

СОРЬЦЫН ТӨРӨЛ, ЗОРИЛГО

Төрөл	Зорилго
Шимт хөрс	Нөхөн сэргээлтэд ашиглах шимт хөрсний чанар, физик шинжийг тодорхойлох зорилгоор сорьц авав. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд шимт хөрсний хими, физик шинж чанарын үзүүлэлт нь хөрсний үржил шимийг тооцоолж, ургамалжуулалтад ашиглах хамгийн тохиромжтой ургамлыг сонгох үндэслэл болдог.
Хөрсний овоолгын чулуулаг	Чулуулгийн овоолго нь байгаль орчны стандартад нийцэж буй эсэх, хүчиллэг урсац үүсгэх эрсдэлтэй эсэхийг тодорхойлох зорилгоор энэ сорьцыг авдаг. Хэрэв чулуулгийн овоолго нь хуульд заасан байгаль орчны шаардлагыг хангаагүй аль эсвэл хаягдал чулууллаг нь хүчиллэг урсац үүсгэж болзошгүй тохиолдолд эрсдэлийг арилгахын тулд нөхөн сэргээлтийн явцад тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Байгаль орчны стандарт шаардлагыг хангаагүй газрыг тохирох хөрсөөр хучиж, хүчиллэг урсацыг багасгахын тулд ус зайлуулах суваг татах гэх мэт арга хэмжээ авдаг.
Хөрсний овоолго	Хөрсний овоолгыг нөхөн сэргээлтийн материал (хучилт хийх материал) болгон ашиглахад тохирох эсэхийг судлах зорилгоор сорьц авсан. Хөрсний овоолго нь хаягдал хадгалах байгууламжтай хамааралтай байдаг. Нөхөн сэргээлтийн явцад байгаль орчны стандарт хэмжээнээс хэтэрсэн хаягдлыг аюулгүй болгож тусгаарлахын тулд хаягдал хадгалах байгууламжид тохирох хучилтын материал ашиглах шаардлага тулгардаг.
Уурхайн карьерийн ус	Уурхайн карьерийн усны чанарыг тодорхойлж, хаалтын дараах болзошгүй эрсдэлийг тооцоолох зорилгоор сорьц авав. Газрын доорх усны шүүрэлт, хур тунадаснаас шалтгаалан уурхайн карьерт гадаргын ус хуримтлагддаг. Усны чанарыг тодорхойлсноор нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөж буй мэргэжилтнүүд олон нийтийн аюулгүй байдлыг хангасан, байгаль орчны стандартад нийцсэн нөхөн сэргээлтийн хамгийн оновчтой стратегийг боловсруулах нэг үндэслэл болно.



Зураг 3. “Эм И Си Эс Зэт Би” компанийн судлаачид Салхитын ордын шимт хөрсний овоолгоос сорьц авч буй нь



Зураг 4. “Эм И Си Эс Зэт Би” компанийн судлаачид Салхитын ордын карьераас усны чанарын сорьц авч буй нь

ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
*Төслийн захирал **Р.Алтангэрэл**тэй имэйл хаягаар холбогдоно уу.*
r.altangerel@merit.mn